



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/642

Есөнбулаг

Хүний папилома вирусийн
халдварын эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1, 60.1.1, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/455 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар 11 настай хүүхдийг дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцин хийх бэлтгэл ажлыг хангуулах, шаардагдах хүн хүч, шатахуун, халдваргүйтгэлийн бодис, ороох боох материал зэрэг зардлыг тооцон санхүүжүүлж, харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн судалгаа гарган, сургуульд суурилсан дархлаажуулалт явуулах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т, зохион байгуулалтын аюулгүй байдлыг ханган дэмжлэг үзүүлж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

4. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах дархлаажуулалтын үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж, иргэдэд зориулсан зөвлөмж, сурталчилгааг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Эрүүл мэндийн газар / Г.Лхагважаргал/-т даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Ж.Амгаланбаатар/, Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (С. Мөнхжаргал) -т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ